



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### XX ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XX хурал 2020 оны 4 дүгээр сарын 28-ний өдрийн 10:00 цагаас Төрийн ордны "Нээлттэй сонсголын танхим"-д 92 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах эсэх талаар;

*Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
хошууч генерал Т.Бадрал*

2. Сүхбаатар аймгийн "Бичигт", Ховд аймгийн "Булган" боомтоор уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг эхлүүлэх бэлтгэл ажил хангагдсан эсэх талаар;

*Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан*

3. Мэргэжлийн болон бусад богино хугацааны танхимын сургалтын үйл ажиллагааг үе шаттайгаар нээх эсэх талаар;

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн  
нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр*

4. ОХУ-ын Түнхэн аймагт байгаа Монгол Улсын иргэд, Улаан-Үд хот дахь Ерөнхий Консулын газрын зарим ажилтан, ар гэрийн хүмүүсийг улсын хилээр нэвтрүүлэх талаар Хөвсгөл аймгийн онцгой комисс, Улаан-Үд хот дахь Ерөнхий Консулын газраас ирүүлсэн хүсэлтийн тухай;

*Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга,  
бригадын генерал Г.Ариунбуян*

## ШИЙДВЭРЛЭСЭН нь:

А. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд сунгах, энэ хугацаанд хилийн боомтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

Б. Монгол Улсын Их хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үед КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Сонгуулийн ерөнхий хороонд Улсын онцгой комиссын зөвлөмж болгон хүргүүлэхээр тус тус тогтов;

Нэг.Зам, тээврийн хөгжлийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,  
Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,  
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

1.1. Говь-Алтай аймгийн Бургастай-Лаоомяо авто замын хилийн боомтоор уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг эхлүүлэх бэлтгэл ажлын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

1.2. Өмнөговь аймгийн Гашуунсухайт-Ганцмод авто замын хилийн боомтоор экспортолж байгаа нүүрсний тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн үйл ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”-ын 2.16-д заасан нөхцлийн дагуу тээвэрлэлтийг зохион байгуулж ажиллах;

Хоёр. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг,  
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Амарсайхан нарт:

2.1. Мэргэжлийн /богино хугацааны/ сургалт зохион байгуулах сургалтын төвүүдийн үйл ажиллагааг үе шаттайгаар нээх, МСҮТ, Политехник коллежийн төгсөх ангийн суралцагчдын үйлдвэрлэлийн дадлагыг эхлүүлэх тухай асуудлыг нарийвчлан судалж бэлтгэлийг хангах талаар Улсын онцгой комисст танилцуулан, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх;

Гурав. Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,  
Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
хошууч генерал Т.Бадрал,  
Хил хамгаалах ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

3.1. Монгол Улсаас ОХУ-ын Улаан-Үд хотод суугаа Ерөнхий Консулын газрын зарим ажилтан, ар гэрийн хүмүүс болон Түнхэн тосгонд байгаа Монгол Улсын иргэдийг нэгдсэн зохион байгуулалттайгаар зөвхөн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг-Хиагт хилийн боомтоор нэвтрүүлэн, тусгаарлалтад авах ажил зохион байгуулах;

3.2. Гадаадаас эх орондоо ирэх хүсэлтээ гаргасан иргэдийг ирэх 5, 6 дугаар сард захиалгат нислэгээр татан авчрах төлөвлөгөө, тооцоо судалгааг Улсын онцгой комисст танилцуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА,  
ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН